



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/13/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3.4.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага.....	11
3.5.6 Үндсэн хөрөнгө	12
3.5.7 Өр төлбөр	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.2 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/228
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.УНДРАХБИЛЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Засаг даргатай байгуулсан "Батламж"-ын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлж 95,9 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Тайлант онд ОНХС-ын эх үүсвэрээр 1, нийгмийн хариуцлагын гэрээгээр 3, нийт 39,000.0 мянган төгрөгийн 4 худаг угсарсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,600,000.0 мянган төгрөгөөр 200 болон 150 мм-ийн диаметртэй дулаалгатай бохирын хоолойг 1300 метр газарт суурилуулсан, аймгийн хөрөнгө оруулалтаар 60,000.0 мянган төгрөгөөр спорт чийрэгжүүлэлт, тоглоомын талбайн ажлууд тус тус хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	790,614.87	1,003,570.14
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	383,912.45	487,198.73
33	АВЛАГА	221,545.50	312,394.99
35	БАРАА МАТЕРИАЛ	185,156.92	203,976.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,527,837.38	4,766,732.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,527,837.38	4,766,732.59
39200	Биет хөрөнгө	4,441,223.38	4,680,734.59
39300	Биет бус хөрөнгө	86,614.00	85,998.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,318,452.25	5,770,302.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	29,491.28	28,128.72
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,491.28	28,128.72
41300	Өглөг	29,491.28	28,128.72
41360	Бусад өглөг	29,491.28	28,128.72
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,288,960.97	5,742,174.00
51	Засгийн газрын хувь оролцоо	5,288,960.97	5,742,174.00
51200	Хуримтлагдсан үр дүн	3,651,898.34	4,105,223.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,318,452.25	5,770,302.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,654,191.14	2,704,228.05
11	ТАТВАРЫН ОРЛОГО	403,529.75	738,047.47
110	Орлогын албан татвар	260,070.00	444,718.88
1100	Хувь хүний орлогын албан татвар	279,577.29	465,718.88
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,507.29	-21,000.00
113	Хөрөнгийн албан татвар	35,479.50	103,400.25
118	Бусад татвар, төлбөр, хураамж	107,980.25	189,928.34
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,069.84	85,502.49
1181	Газрын төлбөр	38,422.67	67,986.94
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	44,487.74	36,438.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,105,761.56	680,627.94
120	Нийтлэг татварын бус орлого	1,105,761.56	680,627.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	177,831.16	134,017.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,144,899.83	1,285,552.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	238,745.50	455,392.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,114.12	220,916.34
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,825,040.21	609,243.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,106,355.64	2,250,903.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,106,355.64	2,250,903.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,753,746.12	2,240,291.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344,448.71	550,716.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,805.14	67,388.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	274,022.98	53,093.06
2104	Хангамж, бараа материалын зардал	59,585.36	61,591.16
2105	Нормативт зардал	137,487.51	108,615.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,877.60	7,192.90
2107	Томилолт, зочны зардал	3,150.30	5,689.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,891.69	104,135.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	850,476.83	1,281,868.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,352,609.52	10,611.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,083.90	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,343,525.62	10,611.86
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	547,835.50	453,325.05
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,591,692.46	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,043,856.96	453,325.05

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,934,136.19	2,321,429.99
11	ТАТВАРЫН ОРЛОГО	403,529.75	788,722.34
110	Орлогын албан татвар	260,070.00	444,718.88
1100	Хувь хүний орлогын албан татвар	279,577.29	465,718.88
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,507.29	-21,000.00
113	Хөрөнгийн албан татвар	35,479.50	103,400.25
118	Бусад татвар, төлбөр, хураамж	107,980.25	240,603.22
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,069.84	83,371.39
1181	Газрын төлбөр	38,422.67	118,661.81
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	44,487.74	38,570.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	385,706.61	247,155.01
120	Нийтлэг татварын бус орлого	385,706.61	247,155.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	126,402.99	71,391.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,144,899.83	1,285,552.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	238,745.50	455,392.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,114.12	220,916.34
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,825,040.21	609,243.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,543,943.85	1,350,156.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,543,943.85	1,350,156.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,186,224.26	1,339,544.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,426.85	550,716.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,531.41	68,673.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	346,556.31	53,093.06
2104	Хангамж, бараа материалын зардал	203,832.48	166,165.21
2105	Нормативт зардал	0.00	1,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,877.60	9,300.00
2107	Томилолт, зочны зардал	3,150.30	5,689.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,569.85	24,326.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,279.45	460,580.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,357,719.60	10,611.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,083.90	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,343,525.62	10,611.86
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,110.08	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	390,192.34	971,273.91
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	484,407.55	731,415.73
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	484,407.55	731,415.73
2200	Дотоод эх үүсвэрээр	484,407.55	731,415.73
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-484,407.55	-731,415.73

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-824.86	-136,571.91
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	824.86	136,571.91
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-95,040.08	103,286.28

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,773,839.94	1,415,599.43	3,303,897.78	7,493,337.16
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,462,061.88	175,000.76	3,651,898.34	5,288,960.97
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,462,061.88	175,000.76	5,695,755.30	7,332,817.94
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,311,778.06	-1,240,598.67	2,391,857.52	-160,519.22
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,043,856.96	-2,043,856.96
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,462,061.88	175,000.76	3,651,898.34	5,288,960.97
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,462,061.88	174,888.73	4,105,223.39	5,742,174.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,462,061.88	175,000.76	3,651,898.34	5,288,960.97
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-112.03	0.00	-112.03
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	453,325.05	453,325.05

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,058,278.10	1,851,688.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,253,812.00	1,149,369.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,252,812.00	1,149,369.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	510,282.40	509,808.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,785.20	63,227.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	507,231.20	408,868.22
2104	Хангамж, бараа материалын зардал	41,954.50	41,855.10
2105	Нормативт зардал	1,000.00	1,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,500.00	23,000.00
2107	Томилот, зочны зардал	5,661.20	5,661.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,528.00	23,084.74
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,869.50	72,863.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	601,024.60	565,747.34
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	203,441.50	136,571.91
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,058,278.10	1,772,032.27
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	467,085.80	455,392.80
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,237,141.50	1,245,248.15
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	354,050.80	71,391.33
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	62	62
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30	30
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30	30

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,114.12	240,865.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,114.12	240,865.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,031.91	229,914.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	38,701.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	4,599.54
2104	Хангамж, бараа материалын зардал	3,833.65	5,838.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400.00	100,179.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,798.26	78,595.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,082.21	10,950.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	9083.9	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,998.31	10,950.41
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81,114.12	240,865.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,114.12	240,865.24

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Борнуур сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Засаг даргатай байгуулсан “Батламж”-ын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлж 95,9 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Борнуур сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд 2023 онд 12 төрлийн ажил төлөвлөж хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд 2021 онд батлагдсан 6 бүлэг, 56 зүйл бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,770,302.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 451,895.2 мянган төгрөгөөр буюу 8,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	383,912.4	487,198.7	103,286.3
Авлага	221,545.5	312,394.9	90,849.4
Бараа материал	185,156.9	203,976.4	18,819.5
Үндсэн хөрөнгө	4,527,837.3	4,766,732.5	238,895.2
Нийт хөрөнгө	5,318,452.2	5,770,302.7	451,895.2
Өр төлбөр	29,491.2	28,128.7	-1,362.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,288,960.9	5,742,174.0	453,213.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,318,452.2	5,770,302.7	451,895.2

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 487,198.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 103,286.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын данс 309,262.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 176,069.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 312,394.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 90,849.4 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн авлага 33,930.0 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн авлага 70,362.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 203,976.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,819.5 мянган төгрөгөөр өссөн нь засаг даргын тамгын газрын бараа материал дансны үлдэгдэл 17,764.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 4,766,732.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 238,895.2 мянган төгрөгөөр өссөн нь засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгийн данс 221,732.3 мянган төгрөгөөр, иргэдийн төлөөлөгчдийн хурлын үндсэн хөрөнгийн данс 13,983.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 5,742,174.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 453,213.1 мянган төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын үр дүнгээс шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 487.198.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 103,286.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	383,912.40	487,198.67	103,286.27
Төгрөг	383,912.40	487,198.67	103,286.27
Төрийн сангийн харилцах	382,295.50	485,234.50	102,939.00
Арилжааны банк дахь харилцах	1,616.90	1,964.17	347.27
Дүн	383,912.40	487,198.67	103,286.27

Эх сурвалж: Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 487,198.6 мянган төгрөгийн 63,5 хувь буюу 309,262.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 15,3 хувь буюу 74,485.1 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 14,5 хувь буюу 70,525.5 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банканд эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 1,964.1 мянган төгрөг байршиж байна.

мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 487,198.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 103,286.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын данс 309,262.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 176,069.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 312,394.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 90,849.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,132.40	2,346.36	(213.97)
Байгууллагаас авах авлага	35,000.00	35,515.36	(515.36)
Хувь хүмүүсээс авах авлага	184,413.10	274,533.27	(90,120.16)
Дүн	221,545.50	312,394.99	(90,849.49)

Эх сурвалж: Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 312,394.9 мянган төгрөгийн 81,5 хувийг буюу 254,595.2 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 203,976.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,819.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	235.14	235.14	-
Тусгай зориулалтын материал	235.14	235.14	-
Эм боох материал	-	-	-
Хангамжийн материал	184,921.75	203,741.28	18,819.53
Бичиг хэргийн материал	-	-	-
Аж ахуйн материал	176,389.50	185,453.33	9,063.83
Сэлбэг хэрэгсэл			-
Түлш шатах тослох материал	-	-	-
Барилгын засварын материал			-
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	8,532.25	18,287.95	9,755.70
Нөөцийн бараа			-
Дүн	185,156.89	203,976.42	18,819.53

Эх сурвалж: Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 203,976.4 мянган төгрөгийн 139,326.0 мянган төгрөг буюу 68,3 хувийг эмийн эргэлтийн сан, 57,620.1 мянган төгрөг буюу 28,2 хувийг ЗДТГ, 3,4 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 203,976.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,819.5 мянган төгрөгөөр өссөн нь засаг даргын тамгын газрын бараа материал дансны үлдэгдэл 17,764.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 7,143,162.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 617,380.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,437,612.55	7,054,993.19	617,380.64
Барилга, байгууламж, орон сууц	323,215.29	323,215.29	-
Авто тээврийн хэрэгсэл	416,497.34	416,497.34	-
Машин тоног төхөөрөмж	132,212.59	146,511.63	14,299.04
Тавилга, аж ахуйн эд хогшил	101,435.97	124,739.36	23,303.39
Зам гүүрийн байгууламж	1,378,984.14	1,476,665.10	97,680.96
Түүх соёлын дурсгалт зүйл	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	4,085,267.22	4,567,364.48	482,097.25
Номын фонд	-	-	-
Биет бус хөрөнгө	88,169.00	88,169.00	-
Программ хангамж	2,545.00	2,545.00	-
Бусад биет бус хөрөнгө	85,624.00	85,624.00	-
Дүн	6,525,781.55	7,143,162.19	617,380.64

Эх сурвалж: Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 4,766,732.5 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,6 хувь буюу 4,746,651.7 мянган төгрөгийг сумын ЗДТГ, үлдэх хувийг эмийн эргэлтийн сан, ИТХ, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 4,766,732.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 238,895.2 мянган төгрөгөөр өссөн нь засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгийн данс

221,732.3 мянган төгрөгөөр, иргэдийн төлөөлөгчдийн хурлын үндсэн хөрөнгийн данс 13,983.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд 38,413.0 мянган төгрөгийн элэгдэл дутуу бодогдсон алдааг аудитын явцад залруулсан.

ЗДТГ-ын санхүүгийн тайланд авто замын их засвар, үерийн далангийн засварын ажлыг сайжруулалтаар бүртгээгүй алдааг аудитын явцад залруулсан.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 28,128.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,912.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүст төлөх өглөг	224.40	0.00	-224.40
Байгууллагад төлөх өглөг	29,816.87	28,128.72	-1,688.15
Дүн	30,041.27	28,128.72	-1,912.55

Эх сурвалж: Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,912.5 мянган төгрөгөөр буурсан нь эргэлтийн эмийн сангийн өглөг буурч, байгаль хамгаалах сангийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 28,128.7 мянган төгрөгийн үлдэгдлийн 26,492.3 мянган төгрөг нь байгаль хамгаалах сангийн, 328.9 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 1,307.5 мянган төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн өглөг эзэлж байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,742,174.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 453,763.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал / Засгийн газрын сан / орон нутгийн сан	1,462,061.87	1,462,061.87	0.00
Хуримтлагдсан үр дүн	3,826,349.09	4,280,112.13	453,763.04
Өмнөх үеийн үр дүн	5,695,755.30	3,651,898.34	-2,043,856.96
Тайлант үеийн үр дүн	(2,044,406.96)	453,325.05	2,497,732.01
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	175,000.75	174,888.73	-112.02
Дүн	5,288,410.96	5,742,174.00	453,763.04

Эх сурвалж: Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 453,763.0 мянган төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудыг үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Борнуур сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,854,836.8 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 582,898.2 мянган төгрөг, 2023 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,854,836.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Борнуур сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2023 оны төсөв батлах тухай” 08 дугаар тогтоолоор 2023 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 582,898.2 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,854,836.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Борнуур сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн “Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлийн жагсаалт төсөв батлах тухай” 08 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлийг 112,570.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,192,141.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 203,441.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 38,038.8 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 112,570.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 1,349,712.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 71,391.3 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 1,192,141.7 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 112,570.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 104,463.8 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,851,688.2 мянган төгрөг буюу 89,9 хувьтай байгаа нь байр ашиглахтай холбоотой зардал 98,392.9 мянган төгрөг, мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Түлш халаалтын зардал 2 соёлын төвийн барилга халаах зардал төлөвлөгөөнд тусгагдсанаас хэмнэгдсэн байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн хөгжлийн сан - хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	550,124.60	514,847.50	35,277.10	93.59%
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага - үндсэн үйл ажиллагааны зардал	581,091.80	574,887.70	6,204.10	98.93%
3	Хоршоо хөгжүүлэх сан - үндсэн үйл ажиллагааны зардал	203,441.50	71,391.30	132,050.20	35.09%
4	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага - үндсэн үйл ажиллагааны зардал	78,110.50	78,096.60	13.90	99.98%
5	Ерөнхий боловсролын сургууль - тогтмол зардал	186,331.60	186,331.60	0.00	100.00%
6	Сургуулийн өмнөх боловсрол - тогтмол зардал	122,707.40	95,736.20	26,971.20	78.02%
7	Эрүүл мэндийн төв - тогтмол зардал	63,488.90	41,302.90	22,186.00	65.06%
8	Соёлын үйлчилгээ - тогтмол зардал	95,473.40	48,104.4	47,369.00	50.39%
		1,880,769.70	1,610,698.20	270,071.50	85.64%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар 230,378.6 мянган төгрөг, ИТХ 10,486.6 мянган төгрөг, нийт 240,865.2 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	100%	78,110.50	78,096.60
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	99%	581,091.80	574,887.70
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	35%	203,441.50	71,391.30
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	186,331.60	186,331.60
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	78%	122,707.40	95,736.20
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	50%	95,473.40	48104.4
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	65%	63,488.90	41,302.90
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	94%	550,124.60	514,847.50

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/74 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,436,211.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 36,543.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 27,407.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Борнуур сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд өөрчлөгдсөн ерөнхий нягтлан бодогчийн нэрийг солиогүй, тайлант онд мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 12 мэдээлэл, мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдэж нийт 4 зөвлөмж өгч, 1 залруулга хийсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 02/218 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	34,056.6	1	34,056.6	100%
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100%
Нийт дүн	2	34,056.6	2	34,056.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг гүйцэтгэлийн аудитаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	5	1	4		1			

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ										
ЗДТГ	2	198,781.3	1	38,412.9	1	160,368.4	2	198,781.3		
Дүн	2	198,781.3	1	38,412.9	1	160,368.4	2	198,781.3		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга								
ИТХ	1	2,104.4	1	2,104.4				
ЗДТГ	4	32,676.0	2	12,207.6			2	20,468.4
Хоршоо хөгжүүлэх сан								
Дүн	5	34,780.4	3	14,312.0			2	20,468.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								